



ХААБ
Хөдөө Аж Ахуйн Бирж

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Биржээр арилжих самнасан ноолуурын арилжааны болон төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Компанийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5.7, "Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК-ийн үйл ажиллагааны ерөнхий журмын 2.8 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/4011 тоот албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн биржээр арилжих самнасан ноолуурын арилжааны шимтгэлийн хувь хэмжээг авах тал 0,5 хувь, зарах тал 0,1 хувиар /нийт 0,6 хувь/ тус тус шинэчлэн тогтоосугай.
2. Самнасан ноолуурын арилжааны төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг авах тал 0,01 хувь, зарах тал 0,01 хувиар /нийт 0,02 хувь/ байхаар шинэчлэн тогтоосугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 15 дугаар тогтоол болон 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
5. Биржээс аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг Биржийн гүйцэтгэх захирал /О.Нарандэлгэр/-д үүрэг болгосугай.
6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /С.Даваасамбуу/-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.БОЛОРЧУЛУУН